

Петро Матад Лимитед
(“Петро Матад” эсвэл “Компани”)

2011 оны 6-р сарын 30-наар дууссан 6 сарын хагас жилийн үр дүнгүүдийн тайлан

Лондон хот, 2011 оны 9-р сарын 30-ны өдөр: Лондонгийн хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлд бүртгэлтэй Монголын газрын тосны хайгуулын компани болох Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани”) нь 2011 оны 6-р сарын 30-наар дуусгавар болсон 6 сарын хагас жилийн аудит хийгдээгүй үр дүнгүүдээ танилцуулж, уг хугацаа дууссанаас хойш явагдсан үйл явдлуудын талаар хувьцаа эзэмшигчиддээ шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

Онцлох Зүйлс:

XX Талбай

- 2011 оны турш өрөмдсөн 8 цооногуудаас бүгдэнд нь нүүрсустөрөгч илэрсэн
- Жилийн эцэс хүртэл туршилтын хөтөлбөр бүрэн хэмжээний хуваариар үргэлжилнэ
- Давсан Толгойн талаарх Компанийн ойлголтыг цааш гүнзгийрүүлэх хүртэл өвлийн турш өрөмдлөгийн үйл ажиллагааг түр хойшлуулж байна
- Давсан Толгойн давхаргазүйн агуулагч давхарга, хагарлаар тусгаарлагдсан хэсгийн талаар дэлгэрэнгүй тодорхойлолтоор хангаж буй дахин боловсруулсан 3 Хэмжээст сейсмийн судалгаа
- XX Талбай дээрх хайгуулын үйл ажиллагаа 2 Хэмжээст сейсмийн судалгаа хийж, мэдээлэл авах хөтөлбөрийн хамтаар Давсан Толгойн ойр орчмын газар нутгаас давж ихээхэн өргөжлөө
 - Одоогийн мэдээллийг дахин боловсруулахтай холбоотойгоор шинэ сейсмийн судалгааг төлөвлөж байна
 - Эхэн үеийн үр дүнгүүд сонирхол их хэмжээгээр татсан олон тооны талбайг тодорхой болгоод байна
 - XX Талбайн өмнөд хэсэгт шинэ ирээдүйтэй сав газрыг олж илрүүлээ
- Ирэх жилийн хавар Монголд айлчахаар Компанийн өрөмдлөг, хайгуулын хөтөлбөрүүдийг дахин эхлүүлэх явдлын бэлтгэлд зориулж техникийн хяналт, мэдээлийн шинжилгээ хийгдэж байна

V Талбай

- 946 км-ын сейсмийн судалгааг 2 сав газарт хийж гүйцэтгэлээ
- Төгрөгийн сав газарт хийсэн эхэн үеийн сейсмийн зүсэлт олон төрлийн агуулагч давхаргын хэв маягийг илрүүлсэн
- Давхаргазүйн өрөмдлөгийн цооногийн чөмөгт дээжээс гарсан шинжилгээний үр дүнгүүд нь Төгрөгийн сав газар үр ашигтай нүүрсустөрөгчийн системийг агуулж байна гэдгийг харуулсан. Эртний газрын тосны “цонх”-ны дээд хэсгийн гүн өнөө үед 1400-1500м байгаа бөгөөд сав газрын гүн 4500м хүртэл гүн байгаа юм.
- Геологийн судалгаа цаашид тос үүсгэгч болон агуулагч давхаргын чулуулгийг тодорхойлно
- Шатдаг занарын илрэл нь боломжит уламжлалт бус нүүрсустөрөгч хуримтлуулагч систем хэлбэртэй илэрч байна

IV Талбай

- Хэд хэдэн сав газрууд дээр 896 км-ын 2 Хэмжээст сейсмийн судалгаа хийж мэдээлэл олж авсан
- Хээрийн судалгаа эх болон агуулагч давхаргын дараалсан үргэлжлэлийг баталгаажуулж, баруун зах хүртэлх талбай дээрх тохиромжтой хураагууруудыг тогтоосон
- Шинээр тодорхойлсон Аргалант хэсэгт ил тодорхой баялаг шатдаг занарын зузаан үргэлжлэлийг агуулсан 700 м-ийн Цэрдийн хэсэгтэй байна. Шинжилгээний үр дүнгүүдийг гаргах ажил явагдаж байна.
- Хойд Улаан Булгийн шатдаг занарын илрэлд уламжлалт бус нүүрсустөрөгч хуримтлуулах системийн тухайд арилжааны шинж чанартай боломж байх магадлалтай.
- Давхаргазүйн чөмөгт дээжийн өрөмдлөгийг IV Талбайн Бигэрийн сав газарт явуулахаар төлөвлөж байна.

Компани

- Хууль, хэрэгжилтийн тасгийг компани дотор байгуулав
- Монголын газрын тосны хуулийн боломжит нэмэлт өөрчлөлтийн талаар Монголын Засгийн газартай үргэлжлүүлэн харилцан ажиллаж байна
- Ойролцоогоор 25 сая ам.долларын одоогийн бэлэн мөнгөний баланстай байна.

Харилцах:

Петро Матад Лимитед
Дуглас Ж. Макгей – Ерөнхий Гүйцэтгэх Захирал (ЕГЗ)
+976 11 331099

Вэстхаус Секюритийз Лимитед
Ричард Бати/Петер Нортон
+44 (0)20 7601 6100

ЕРӨНХИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭДЭГДЭЛ

Дэлгэрэнгүй

Тойм

Энэхүү мэдэгдэл 2011 оны эхний 6 сарын нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг хавсаргаж, энэхүү хугацаан дахь томоохон үйл явдлуудын талаар мэдээлэл хийхийн зэрэгцээ 7-р сарын 1-нээс өнөөг хүртэл тохиолдсон үйл явдлуудыг хамрах болно. Тиймээс энэхүү мэдэгдэлд өгүүлэх үе нь 2011 оны 1-р сарын 1-нээс хойшхи 9 сарын үеийг агуулж байгаа юм.

Үйл ажиллагааны үүднээс харвал уг хугацаанд Компани нь томоохон өсөлтийг үзүүлж, тус хугацааны зорилгуудын ихэнхэд хүрлээ. Бидний Давсан Толгой дахь 2011 оны өрөмдлөгийн хөтөлбөр нэмэгдсэн үр ашиг, хэмнэлтийн хамтаар жигд явагдаж, цооногийн туршилтын хөтөлбөр ид явагдаж байна. Мөн, бидний өргөн хэмжээний 2011 оны сейсмийн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгдэж, компанийн мэргэжлийн геологийн шинжлэх ухааны үйлчилгээг Компанийн хайгуулын болон үйл ажиллагааны философийг биелүүлэхийн тулд онцгой сайн үзүүлж ажиллалаа. Улмаар, манай корпорацийн, хуулийн болон захиргааны багууд хүчирхэг компанийн засаглалын дэг журмыг бий болгож, Монгол улс дахь орчин үеийн бизнесийн үйл ажиллагаанд жишиг тогтоож өглөө.

Давсан Толгой дахь үйл ажиллагаагаа урагшлуулахад тодорхой хэмжээгээр өөрсдийгөө сайжруулах үе байсан гэж хэлж болно. Давсан Толгойн хэтийн төлвийг олборлох боломж бүхий томоохон газрын тосны талбай мөн гэдгийг батлах болно гэдэгтээ Компани итгэлтэй байгаа боловч өнөөг хүртэлх өрөмдлөг, туршилтын үр дүнгүүд геологийн бүрдэл нь нарийн төвөгтэй бөгөөд илүү бүрэн дүүрэн ойлголтод хүрч, нөөц нь илүү тодорхойгоор зураглагдахын өмнө цаашдын ажил хийх хэрэгтэй юм.

Энэхүү ойлголт авч үзэж үеийн сүүлийн хэсэг дэх дэлхийн зах зээлийн ерөнхий сул дорой байдлын хамтаар Компанийн зах зээлийн үнэлгээг 1-р сарын 1-нээс одоог хүртэл 63%-иар унахад хүргэлээ. Энэ нь мөн одоог хүртэл бидний олж авсан бүх мэдээллийн геологийн дахин үнэлгээний хамтаар хянагдаж, цаашдын мэргэжлийн бөгөөд эерэг арга замуудыг зурагдаж байх зуур Давсан Толгойд бүтэн жилийн турш үргэлжлэх өрөмдлөгийг болиулах шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) гаргахад хүргэсэн. ТУЗ нь одоо үед өвөлжүүлсэн тоног төхөөрөмж болон бүтэн жилийн өрөмдлөгт их хэмжээгээр хөрөнгө оруулахаас илүүтэй Компанийн одоогийн цооногуудийг гүйцээж турших улмаар уг мэдээллүүдээс тодорхой болох дараачийн үнэлгээний ажилд өнөөг хүртэл хийгдсэн бусад өрөмдлөгийн ажлын хамтаар анхаарлаа төвлөрүүлэх шийдвэр гаргасан.

Давсан Толгой дээрх ажил дээр нэмэгдэн, ХХ Талбайн үлдсэн хэсэг болон Монголын төв хэсгийн IV, V Талбайн өргөн уудам талбайг хамарсан Петро Матадын бусад хайгуулын хөтөлбөрүүд доор дурдсаны дагуу маш урамтай үр дүнгүүдийг гаргалаа.

ТУЗ болон компанийн удирдлага Петро Матадын ирээдүйд маш итгэлтэй хэвээр байна. Бидэнд өөрсдийгөө урагш дагуулах хангалттай бэлэн мөнгөний нөөц байгаа бөгөөд Монголд байгаа томоохон хайгуулын хэтийн төлвийг хамгийн дээдээр ашиглах боломжийг бидэнд олгохын зэрэгцээ Компани нь онцгой мэргэшсэн багтай байна.

Энэхүү тайланд миний бие тэдгээр хайгуулын боломжуудыг нарийвчлан авч үзэж, сүүлийн 9 сарын хугацаанд Компанийн хүрсэн амжилтуудыг дурдах болно.

ХХ Талбай Давсан Толгой

Өрөмдлөг

Компани нь Давсан Толгой Хэтийн төлөвтэй талбайд 11 цооногийг одоогоор өрөмдөөд байна. Эхний 3 цооногийг 2010 онд өрөмдсөн бөгөөд үлдсэнийг нь 2011 онд өрөмдсөн болно. Сүүлийнх буюу ДТ-11 цооногийг саяхан өрөмдөж дуусгаж байгаа бөгөөд тайлан мэдээг нь удахгүй мэдээлнэ. Гэрээлэгчийн (Ди Кью И Интернэшнл) өрмийн цамхгийг 2012 онд өрөмдлөгийг эртхэн дахин эхлүүлэхийн тулд талбай дээр хурааж орхиод байна.

11 цооногийн үр дүнгүүдийг доорхын дагуу дүгнэж болно. Үүнд:

Цооног	Тооцоолсон Тост Үе	Формац	Дундаж Нүх Сүвшилт	Тосны Илрэл	Хийн Муруй Өсөх	Тэмдэглэл	Цаашдын ажлын төлөвлөгөө
ДТ-1	17 м	Дээд Цагаанцав	25%	Байгаа	Байгаа	3 бүстэйгээс нэг нь нарийн	Эвдрэлийг цементлэх ажлын улмаас битүүмжилж орхисон
ДТ-2	5 м	Дээд Цагаанцав	20%	Байгаа	Байгаа	Нэг гол бүс	2011 онд туршилт хийнэ

ДТ-3	8 м	Дээд Зүүнбаян	23%	Байгаа	Байгаа	Шингэний Ормын Туршилтын судалгаагаар нэмэгдсэн	2011 онд туршилт хийнэ
“	5 м	Доод Цагаанцав	25%	Байгаа	Байгаа	Формацийн дээд хэсэг, үлдсэн нь урссан	2011 онд туршилт хийнэ
ДТ-4	5 м	Доод Цагаанцав	11%	Байгаа	Байгаа	Чөмөгт дээж оргилж буй газрын тосыг илрүүлсэн ч хатуу чулуулагтай байна	Ан цавын давхаргын гарцыг сайжруулахыг хүлээж байна
ДТ-5	3 м	Дээд Цагаанцав	10%	Байхгүй	Байгаа	Эртний сувгийн суурь элсэн чулуулаг	Одоогоор туршилт хийх төлөвлөгөөгүй байна
ДТ-6	Байхгүй	Дээд Цагаанцав	16%	Байхгүй	Сул	Хуурай цооног – нүүрсустөрөгч илрээгүй	Битүүмжилж орхих – хуурай цооног
ДТ-7	5 м	Дээд Цагаанцав	25%	Байхгүй	Сул	Их хэмжээний усны зүсэлт байх магадлалтай	Одоогоор туршилт хийх төлөвлөгөөгүй байна
ДТ-8	8 м	Дээд Цагаанцав	19%	Байгаа	Байгаа	Формацийн дээд хэсэгт тосны илрэл гарсан	Одоогоор туршилтыг дуусгаж байна
ДТ-9	8 м	Доод Цагаанцав	23%	Байгаа	Байгаа	Ойролцоогоор 50 м-ээс дээш тост үетэй нимгэн бүст тосны илрэл, хий олдсон	Битүүмжилж орхисон – шингэн
ДТ-10	Байхгүй	Доод Цагаанцав	----	Байхгүй	Сул	Хураагуур цоороод тос алдагдсан – хөдөлгөөнгүй үлдэгдэл тос	Битүүмжилж орхисон – хуурай цооног
ДТ-11		(өрөмдлөг хийгдэж байна)		Байгаа	Байгаа	1078 метрт газрын тосны сайн илрэл байж, чөмөгт дээж авсан. 3 туршилтын бүстэй. Good oil shows at 1078m, cored. Three test zones.	2011 онд туршилт хийгдэнэ.

11 цооногоос 7-д нь нүдэнд харагдахуйц газрын тосны илрэл байсан бөгөөд энэ нь СОКО Интернэшнл болон Петро Чайнагийн хоёулангийн XIX Талбай дээр хайгуул, үнэлгээний өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулж байх үеийн 30.4%-ийн амжилтын түвшинтэй харьцуулахад гайхалтай амжилт юм. Өрөмдлөгийн үйл ажиллагаа Монголын Газрын Тосны Газарт нэгтгэгдэж 2009 онд XIX Талбайд 835 сая баррель батлагдсан газрын тосны STOIP нөөц, 2.5 тэрбум м³ байгалийн хийн нөөц байгааг зарласан.

Дээрх өрөмдлөгийн үр дүнгүүд Давсан Толгой болон түүний орчим дахь бусад хайгуулын үйл ажиллагааны хамтаар Компанийг дараах урьдчилсан дүгнэлтэд хүргэж байна. Үүнд:

- Газрын тос хол зайн турш бүтцийн болон давхаргазүйн хураагуур луу шилжсэн байна
- Хураагуурууд дутуу бөглөгдсөн бөгөөд энэ нь шилжсэн газрын тосны хэмжээ бага юмуу бөглөгдсөн хураагуурууд дараа нь цоорч тос алдагдсан гэдгийг илэрхийлж байна. Илрэлийн тархалт, шингэний ормын үр дүнгүүд болон ихэнх цооног дахь үлдэгдэл тосны тооцоо хоёрдогч үр дүнг харуулж байгаа боловч батлахгүй байгаа юм.
- Өвгөн Голын эртний голын хөндийн үзэл баримтлал үр дүнтэй гэдэг нь батлагдсан ч, эртний голын хөндийн дүүргэлтийн дотоод давхаргазүй нь нарийн төвөгтэй байгаа юм.
- Эртний голын хөндийн хэтийн төлвийн хэмжээсүүдийг өөрчлөх шаардлагатай. Уг өөрчлөлтийн үр дүнгүүд 2011 оны 3-р сард зарласнаас бага хэмжээтэй дундаж хэтийн төлөвтэй нөөцийг харуулах болно.
- Баруун хойноос хойш чиглэсэн хагарлууд цоорхой байх төлөвтэй бөгөөд ингэснээрээ тэдний зүссэн хэтийн төлвүүдийг цоорч тосоо алдсан байх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Тос олборлох гал зууханд илүү ойрхон хагарлын хураагуурууд цоорч тосоо алдсан байх магадлал багатай байна.
- Бүтээмж сайтай тос үүсэх гал зуухны ойролцоох хагарлын хураагуурууд литостатик ачаалал ихтэй учир цоорч, тос алдах магадлал бага байдаг
- Давсан Толгойн гүдэн бүтцийн зүүн хэсэг дэх Петро Чайнагийн цооногуудад газрын тос байгаа нь Зүүн Тосонгийн галзуухуудад олборлолт явуулж болно гэдгийг хүчтэй санал болгож байна. Энэ нь Давсан Толгойн зүүн хэсэгт хайгуулын цооног өрөмдөхийг урьдчилан хэлж байна.

- Давсан Толгойн баруун хэсгийн газар нутгийн өмнө нь хийгдсэн 2 Хэмжээст судалгааг сүүлийн хэдэн сард дахин зураглаж, зарим сонирхолтой гүнзгийг хэтийн төлөвтэй талбай ба/буюу хэтийн төлөв сайтай талбайнуудыг тодорхойлж байна. Эдгээрт оновчтой цооногууд эрт үеийн, хөндлөн хотгорууд бүхий гүдэн бүтцэд байх төлөвтэй Тосон Уулын талбайнуудтай төстэй шинж чанар байна.

Цооногийн өрмийн үйлчилгээний цамхаг тодорхойлсны дагуу ажиллаж, Компани нь хөтөлбөрийн үйл явцад сэтгэл хангалуун байна.

Туршилт

Компанийн талбайн алслагдмал байдал, тоног төхөөрөмжийг хилээр нэвтрүүлэх, бараа материалын хангамж болон Компанийн өрмийн багийнхан барууны стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр цооногийн туршилт гүйцэтгэхээр шийдвэрлэсэн зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан цооногийн туршилтыг хойшлуулсаны эцэст Ди Кью И Интернэшнл компанийн цооногийн үйлчилгээний иж бүрэн цамхагийг тохирох туршилтын тоног төхөөрөмжийн хамт Хятад улсаас авчран 2011 оны 08 дугаар сарын эхээр туршилтыг эхлүүлсэн. Компанийн өрмийн баг агуулагч давхаргын инженер, туршилтын инженерүүдээр боловсон хүчнээ нэмэгдүүлэн ажиллаж байна.

Өнгөрсөн онд өрөмдсөн цооногуудад цементацын доголдол үүссэн талаар бид өмнө нь мэдээлсэн. Тухайн үед ДТ 1-3 цооногуудын цементийн барьцалдах чанарын бичиглэлээр цаашид хүндрэл учирч болзошгүйг тогтоосон хэдий ч цооногуудын цементацын доголдлын хэмжээг тодорхойлох цорын ганц боломж нь цооногийн туршилт байсан.

ДТ-1 цооногийн туршилтаар өмнөх туслан гүйцэтгэгч компани цементацын хэмжээг хэтрүүлсэнээс ноцтой гэмтэл үүсч, 1073-1079 метрийн гүнд байгаа судалгааны үндсэн хэсэг ашиглах боломжгүй болсон байна. Тус интервалыг орлуулж, туршихаар ДТ-11 цооногийг өрөмдсөн. Цооногийн доод интервалаас туршилтыг эхлүүлсэн бөгөөд тосны урсгал 20 баррель, мөн усны агууламж өндөр байсан. Шинжилгээгээр ДТ-1 цооногоос авсан тос 25° API үзүүлэлттэй (API-Америкийн Нефтийн Институт, АНИ-ын нягтын нэгж) байсан. Цооногийг цементлэх явцад формацийн гэмтэл, хагарал үүсч, тус интервалд нөлөөлсөн нь даралтын хэмжилтээр тогтоогдсон. Мөн түүнчлэн судалгааны энэ үе нь урт хугацааны олборлолт хийхэд тогтвортой бус, эдийн засгийн үр ашиггүй гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Дараагийн туршилтыг ДТ-9 цооногт гүйцэтгэсэн. Петрофизикийн шинжилгээгээр Цагаанцавын формацид нилээд хэмжээний нүүрсустөрөгчийн үе ялгасан. Туршилтаар цооногоос цэвэр ус ялгарсан бөгөөд Цагаанцавын Формациас ялгарч буй давслаг устай харьцуулбал эсэргүүцлийн шинж чанар нь нүүрсустөрөгчийн эсэргүүцэлтэй ижил байна.

Цооногийн туршилт үргэлжилж байгаа бөгөөд ДТ-4 цооногийн хариуг энэ долоо хоногийн эхээр хүлээж авсан ба ДТ-8 цооногийн үр дүнг хүлээж байна. ДТ-11 цооногийг туршсаны дараа цооногийн үйлчилгээний цамхагийг энэ жилийн ажил дуусгавар болохоос өмнө ДТ-2 болон ДТ-3 цооног руу нүүлгэнэ.

Цооногийн туршилтын одоогийн үр дүн:

Цооног	Формаци	Интервал	Гүн	Олборлосон шингэний хэмжээ	Тэмдэглэл
ДТ-1	Дээд Цагаанцав формацийн дээд хэсэг	C1-1	1123-1127	~20 баррель тос /өдөр 25API	Усны агууламж өндөр
“			1117-1119		
“			1111-1113		
“	Дээд Цагаанцав формацийн дээд хэсэг	C2-1	1100-1104	Шингэн олборлолт маш бага	Нэвчүүлэмж багатай чулуулаг
“			1090-1094		
“	Дээд Цагаанцав формацийн	C3-1	1073-1079	>1300 баррель цэвэр ус /өдөр	Формацийн эвдрэл - суурь чулуулгийн уст давхаргаас ус нэвчсэн

	дээд хэсэг				
ДТ-9	Доод Цагаанцав	C1-1	1639-1648	200 баррель цэвэр ус /өдөр	Формациас ялгарсан шингэн
ДТ-4	Доод Цагаанцав	C1-1	1838-1842	Шингэн олборлолт маш бага, тосны ул мөртэй	Нэвчүүлэмж багатай чулуулаг, хагалбар хийхэд тохиромжтой
“		C2-1	1798-1801	Ногоон хүрэн өнгийн тос ~42API	Нэвчүүлэмж багатай чулуулаг, хагалбар хийх шаардлагатай
“			1795-1798		

Цооногийн туршилтыг ирэх гурван сарын хугацаанд гүйцэтгэж, өвлийн цочир хүйтрэлтээс өмнө дуусгахаар төлөвлөж байна. Тохирох үед цооногт шингэн хагалбар хийж, шингэн хагалбарын олборлолтонд нөлөөлөх байдлыг судална. Компани шингэн хагалбар гүйцэтгэх туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, анги зохион байгуулалтыг хэлэлцэж, тохиролцохоор ажиллаж байна. Одоогоор хагалбарын ажлыг гүйцэтгэх тов гараагүй байна.

Сейсмийн судалгаа

Өнгөрөгч хавар Давсан Толгойг хамарсан 3 хэмжээст сейсмийн судалгааны мэдээллийг дахин боловсруулан давтамжийг өндөрсгөж, сейсмийн мэдээллийн чанарыг сайжруулсан. Дахин боловсруулалт маш амжилттай хийгдэж, давхаргазүйн онцлогууд болон хагарлын талаар илүү тодорхой мэдээлэлтэй болсон. Компанийн геофизикийн мэргэжилтнүүд дахин зураглалыг ажлыг амжилттай гүйцэтгэж ойрын хугацаанд хугацаанд дуусгахаар ажиллаж байна. Бид өрөмдлөг, цооногийн туршилтын мэдээллийг дээрхи сайжруулсан зураглалтай нэгтгэж, ирэх саруудад Давсан Толгойн геологийн орчны талаар бүрэн ойлголттой болно. Энэхүү ажлын хүрээнд эзлэхүүнийг шинээр тогтоож, 2012 онд Давсан Толгойд хэрэгжүүлэх өрөмдлөгийн хөтөлбөрийн саналыг боловсруулна.

Матад ХХ талбай – Давсан Толгойгоос бусад хэсэг

Петро Матад компани Давсан Толгойд эрчимтэйгээр хайгуулын ажил гүйцэтгэхийн зэрэгцээ хайгуулын цар хүрээг өргөжүүлэн Матад ХХ талбайн үлдсэн хэсэгт судалгаа хийсэн.

Энэхүү нэмэлт судалгааны хүрээнд Давсан Толгойтой зэрэгцээ талбайдад өмнө нь хийгдсэн 2 хэмжээст сейсмийн судалгааны мэдээллийг дахин боловсруулан зураглаж, 1,256 км-ийн 2 хэмжээст сейсмийн хэмжилт хийж, мэдээллийг боловсруулсан бөгөөд одоогоор зураглалын ажил хийгдэж байна. Сейсмийн судалгаа Хятад улсын туслан гүйцэтгэгч Би Жи Пи Инк. (BGP Inc) компани вибросейсмийн аргаар гүйцэтгэсэн.

Өмнө нь Давсан Толгойн баруун хэсэгт хийгдсэн 2 хэмжээст сейсмийн судалгааны мэдээллийг дахин зурагласнаар урьд нь ялгасан хэтийн төлөв сайтай болон хэтийн төлөвтэй талбайдыг илүү тодорхой болгож, XIX талбайн Тосон Уулын ордын хураагууртай ижил төрлийн бүтцүүдийг өрөмдөх байршлуудыг шинээр тодорхойлсон. 2011 оны хайгуулын хөтөлбөрийн хүрээнд талбайн ойр орчимд 2 хэмжээст сейсмийн нэмэлт хэмжилт хийж, хэмжилтийн мэдээллийг мэдээллийн санд оруулсан бөгөөд ирэх саруудад дүн шинжилгээ хийгдэнэ.

Мөн хугацаанд Давсан Толгойн зүүн хэсэгт судалгаа хийгдсэн. Өмнөх 2 хэмжээст судалгааны дахин зураглалаар 2011 оны 03 дугаар сард хийсэн үнэлгээнд хамрагдсан эртний голын хөндий болон нүүрсустөрөгч хуримтлуулах системүүд тогтоогдсон. Зүүн Тосон Уулын ховдол нь Петро Чайна компанийн XIX талбайн өрөмдлөгийн мэдээлэлд энэхүү ховдлыг зүүн Давсан Толгойн хэмжээнд бүрэн судлагдаагүй тос үүсгэх чухал эх үүсвэрийг бүрдүүлж байгааг харуулсан байна. 2011 оны хайгуулын хөтөлбөрийн хүрээнд энэ хэсэгт шинээр арван зургаан шугам тавьж, нийт 349 км-ийн 2 хэмжээст сейсмийн хэмжилт хийгдсэн. 2 хэмжээст судалгааны эцсийн боловсруулалтын анхны үр дүнгээр судалгааны талбайн хэмжээнд Өвгөн голын эртний голын хөндийн нүүрсустөрөгч хуримтлуулах систем болон Тосон Уулын ордын Доод Цагаанцавын хураагуурын төрөлтэй дүйцэх гүвдэл, ховдлын хэд хэдэн суналууд илэрсэн. 2 хэмжээст судалгаагаар тус бүс нутагт шинэ төрлийн хураагуурын бүтцүүдийг үүсгэж буй, урьд өмнө нь тэмдэглэгдээгүй шахагдмал /сжимающийся/ гүдэн бүтэц, тохролт /зэрсөн/ хагаралуудын суналыг тогтоосон.

Матад ХХ талбайд гүйцэтгэсэн 2 хэмжээст сейсмийн судалгаа нь тус талбайн өмнөд болон төв хэсэгт, Эрдэнэцагаан, Эрдэнэцагааны зүүн хэсэг болон Асгатын сав газрыг судлахад чиглэгдсэн. Сейсмийн судалгааны үр дүнд дээрхи талбайд нь Матад ХХ талбайн хойд хэсэгтэй ижил гүнтэй бөгөөд Тосон Уулаас бага зэрэг гүехэн байгаа нь тогтоогдсон. Талбайн өмнөд хэсгийн грабенуудын сейсмийн долгионы хурд өндөр байгаа нь тэдгээрийн булагдал гүн байгааг илтгэж байна. 2 хэмжээст сейсмийн зураглалаар XIX талбайн Тосон Уулын ордын тос хуримтлуулах бүтцүүдтэй ижил, сав газрын доторхи гүвдэл, ховдлын хэд хэдэн суналуудыг ялгасан.

Том масштабтай Монгол орны геологийн зургууд дээр тэмдэглэгдсэн Кайнозойн галт уулын чулуулгийн доор орших Цэрдийн галавын гүн сав газар ХХ талбайн өмнөд хэсгийн 2 хэмжээст сейсмийн шугамуудаар тогтоогдсон. Энэхүү шинээр тогтоогдсон сав газар нь Доод Цагаанцавын формацийн түвшинд сав газрын доторхи гүвдэл, ховдлоос бүрдэнэ. Петро Матад компани Матад ХХ талбайн өмнөд хэсэгт 4000 цэгтэй хүндийн хүчний судалгаа гүйцэтгэж, сав газрын хязгаарыг тогтоож, цаашид тус талбайд хийгдэх сейсмийн судалгааны чиглэлийг тодорхойлно.

Дээр дурдсан 2 хэмжээст сейсмийн судалгааны зураглал, үнэлгээг өвлийн саруудад үргэлжлүүлж, тэдгээрийн үр дүнг хугацаанд нь гарган 2012 онд гүйцэтгэх дараагийн шатны хайгуулын хөтөлбөрийг төлөвлөнө.

V талбай

Тус хугацааны турш V талбайд хайгуулын үндсэн гурван чиглэлийн үйл ажиллагаа буюу чичирхийллийн 2 Хэмжээст судалгаа, давхаргазүйн чөмөгт дээжийн өрөмдлөг ба талбайн геологийн судалгааг хийв. Үүнийг тодруулбал:

- Таацын Цагаан нуурын сав орчим газраар 495 км туршид үргэлжлэн тархсан 2 Хэмжээст вибросайс (чичирхийллийн) судалгаа (Синопекээр гүйцэтгүүлэв)
- Монголын гэрээлэгч компани Хэт ХХК-р тэсрэх бодис ашиглан 2 Хэмжээст чичирхийллийн судалгааг 451 км газарт ойр зайтайгаар хийв. Үүнийг 2010 оны тандалтын судалгаагаар тун “ирээдүйтэй” хэмээн тодорхойлогдсон Төгрөгийн сав орчим газраар хийсэн юм.
- Төгрөгийн сав газрын бэлд 1600 м гүн өрөмдлөгийн цооногийг стратиграфик судалгаа хийх зорилгоор Мэйжор Дриллинг компаниар гүйцэтгүүлэв.
- Манай компанийн геологийн хэлтэс Монголын газрын тосны геологийн талаар өргөн мэдлэгтэй АНУ-ын зөвлөхүүдийн хамт геологийн судалгаа хийв.

2011 онд хийгдсэн бүх чичирхийллийн судалгаа нь 2010 онд IV, V Талбайд анх хийж байсан 2 Хэмжээст хөтөлбөрийн судалгаанаас илүү их үзүүлэлтүүдийг илрүүлснийг онцлон тэмдэглэх хэрэгтэй байна.

Илүү өргөн тархацтай нутгийг хамрах 2 Хэмжээст чичирхийллийн судалгааг бүрэн хийж дууссан бөгөөд тус судалгааны зургийг гаргаж, дүн шинжилгээ хийх ажлыг энэ өвөл хийх гэж байна.

Эдийн засгийн өндөр үр ашигтай байж болох тус газар тэсрэх бодисын аргыг ашиглах нь илүү нарийвчилсан үр дүнд хүргэнэ гэж үзсэн тул Төгрөгийн сав орчмын газарт 2 Хэмжээст чичирхийллийн судалгааг тэсрэх бодис ашиглан хийж, тус судалгааг урьдны хийсэн аргачлалтай харьцуулсан. Судалгаа нь хоорондоо 4км орчмын зайтай перпендикуляр шугамуудын сүлжээсээс бүрдэж байв. Энэхүү судалгааг нягтлан үзэж байгаа бөгөөд, зураглал хийх ажлыг 10-р сард эхэлнэ. Үүний гол зорилго нь бүтцийн ерөнхий байдал ба газрын давхаргын зураг гаргаж, нүүрсустөрөгчийн агууламжийг тооцоолох, бүтцийн шилжилтийг тодорхойлох, мөн чадамжтай оршдос болон түүний агууламжийг тодорхойлох юм. 2010 онд анх хийсэн судалгаатай харьцуулахад Төгрөгийн сав орчмын газар нь 3000 м гүн байж болзошгүй хэмээн үзэж байна.

Төгрөгийн сав газрын 250км² талбайн хойд хэсгийн давхаргазүйн цооногос илэрсэн дээжид шинжилгээ хийж, компанийн зөвлөхүүдэд мэдээллэн, мөн АНУ-ын лабораторид шинжлүүлэхээр явуулсан байгаа. Каротажийн ажил ба дээж авалтын үеэр чулуулгийн давтамжийн хоёр эх сурвалж тааралдсан бөгөөд илүү гүн эх сурвалж нь бараг 100м зузаан, дунджаар нийт 3%-ийн органик өсөлттэй (ТОС) байсан ба одоогоор бүрэн боловсорч, түүхий тос гаргаж эхлээд байна. Мөн тус шинжилгээнд Шингэн агууламжийн судалгаа бас орсон байгаа. Эдгээр судалгааны үр дүнг дөнгөж саяхан ирүүлсэн.

Дээжийн шингэн агууламжийн судалгаагаар шингэн түүхий тосны төрөл, мөн хуурай болон нойтон хийн орц байгааг илрүүлэв. Үүнээс гадна өрмийн цооногийн ойролцоо хийн агууламж байх магадлал ажиглагдсан ба үүнээс үүдэн хийсэн петрографийн судалгаагаар дээжид тосны агууламж байгааг баталсан байна. Энэ бүх мэдээллээс үзэхэд, нүүрсустөрөгчийн нэлээд хэдэн шилжилт явагдаж, эдгээр нь өрмийн цооногт харимтлагдаагүй болохыг харуулж байна.

Төгрөгийн сав газар нь эдийн засгийн үр ашигтай нүүрс устөрөгчийн системийг агуулж байгааг дээжийн цооног баталж байна гэсэн дүгнэлтэд дээрх судалгааны үр дүн хүргэж байгаа ба тосны агууламж 1400-1500м гүнд байрлаж байна. 1400-1500м дээш гүнд орших Төгрөгийн сав газрын бүх хэсгийг газрын тос бүрэлдэх орчин болсон гэж үзэж болох ба урьд нь 3000м гүнд хийж байсан судалгааны хариу зөв гарсан бол бүр байгалийн хий ч үүсэх орчин болсон гэж үзэж болохоор байна.

Энэ үе нь Монголын газрын тосны хайгуул хөгжин цэцэглэх түүхэн үе юм. Петро Матад нь нүүрсустөрөгчийн агууламжийн чадамжийн хувьд урьд өмнө хэзээ ч судлагдаж байгаагүй газарт орчин үеийн нарийвчилсан судалгааг анх хийж байгаа байгууллага бөгөөд амьд нүүрсустөрөгчийн тогтолцоо баттай илэрсэн нь бидний зүтгэлийн багагүй ололт болоод байна.

Энэ хугацааны турш V талбайд геологийн нарийвчилсан судалгааны экспедици явагдлаа. Эдгээрийн үр дүнг одоогоор боловсруулж дуусаагүй боловч ерөнхий дүгнэлтээс харахад тус сав газрын уртрагийн дагуу шатдаг занар тогтмол илэрч, мөн шатдаг занарын эх сурвалж болох чулуулгийн дээр, доор ба солбицолд нөөц байгаа нь тогтоогджээ.

Экспедицийн судалгаа нь мөн V талбайд илэрсэн ба байж болох шатдаг занарын агууламжийн чадамж ба насыг тэмдэглэсэн байна.

IV талбай

Судалгааны үеэр IV талбайд явуулсан хайгуулын үйл ажиллагаа:

- Бигэр, Баянцагаан, Дэлгэр ба Баацагаан орчмын сав газраар (одоо ч хийгдэж байгаа) хол зайтайгаар 896 км 2D хэмжээст вибросайс чичирхийллийн судалгаа (Синопек компаниар хийлгэв)
- Геологийн экспедици
- Хойд Улаан булгийн шатдаг занарын илэрцийн нарийвчилсан геологийн судалгаа

2 Хэмжээст судалгаа нь бараг дуусах гэж байгаа бөгөөд тус мэдээллийг боловсруулж, зургийг нь гаргаж, мөн энэ өвөл шинжлэн дүгнэх болно.

Геологийн экспедицийн судалгаагаар сав газрын уртрагийн дагуу шатдаг занарын илэрцийн тоо ба газарзүйн байршлын хэмжээ нэмэгдсэн бөгөөд эх сурвалжийн чулуулгийн зузаан, чадамж, боловсролтын түвшин буюу насыг тэмдэглэж, шатдаг занарын давтамжийн дээр, доор ба доторх нөөцийн чулуулгуудын шинж чанарыг тодорхойлсон байна. Эцэст нь дүгнэхэд, геологийн багууд эх сурвалжийн чулуулаг, нөөцийн чулуулаг, талбайн баруун хэсэгт урьд нь хэзээ ч тэмдэглэгдэж байгаагүй нүүрстөрөгчийн агууламжийн тогтолцоо байгааг баталсан. Экспедицийн баг бүр тус талбайн баруун хязгаар хүртэл эдгээр илэрц байгааг амжилттайгаар тогтоожээ. IV талбай ба түүний ойр орчим урьд илэрсэн шатдаг занарын зургаан илэрц нь энэ жилийн судалгаанд мөн орсон болно.

IV ба V талбайн (Бигэр) алслагдсан байршил ба шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл байхгүйн улмаас Петро Матад одоогоор Мэйжор Дриллинг компанид тус сав газарт давхаргазүй ба бусад төрлийн судалгаа хийх зорилгоор хоёр дахь дээжийн цооног өрөмдөх үүргийг өгөөд байна. Тэдгээрийг дээр өгүүлсэн Төгрөгийн сав газрын өрмийн цооногт хийсэн судалгааны адилаар шинжлэн дүгнэх ба энэ нь манай чичирхийллийн судалгааг баяжуулахын зэрэгцээ тус урьд өмнө хэзээ ч судлагдаж байгаагүй газрын талаар үнэтэй мэдээллийг өгөх болно.

Хайгуулын улирлын гол ололт амжилт нь Аргалант гэгдэх шинэ бөгөөд нилээд томоохон шатдаг занарын илэрцийг тодорхойлсон явдал юм. Тус илэрц нь ойролцоогоор 200 м органик занар ба аргиллит агуулсан 700 м Цэрдийн галавын давхаргатай байх магадлалтай байна. Нарийвчилсан судалгааны дээжийг цуглуулж, одоогоор шинжилж байна.

Хойд улаан булгийн шатдаг занарын илэрцийг геологийн нарийвчилсан зураглал ба 2D хэмжээст зургийг гаргахаар өгчихөөд байна. Энэ хэсэгт илэрцийн гүнийг тодорхойлох ба дээж авах зорилгоор хоёр гүехэн цооногийг өрөмдөх болно. Энэхүү илэрцийн гадаргууны шинжилгээгээр маш өндөр хэмжээний ТОС ба Фишер Ассэйн судалгааны дүн илэрсэн ба эдгээр үр дүн газрын гүнд болон илэрцийн бүх хэсгүүдэд адил хэвээр байвал, Хойд улаан булаг нь эдийн засгийн үр ашигтай шатдаг занарын орд болж чадахаар байна (боловсруулалт ба дэд бүтцээс хамаарна).

Дүгнэлт

Судалгааны үеэрх Петро Матадын хурдацтай өсөлтийн талаар Жилийн тайланд дэлгэрэнгүй өгүүлсэн байгаа. Бид компанийнхаа техникийн багийг зохих түвшний нөхцлөөр хангах, компанийн засаглалын болон захиргааны тогтолцоог бүрдүүлэх тал дээр ихээхэн дэвшилт гаргасан. Энэхүү өсөлт хөгжил нь сүүлийн гурван сард удааширсан бөгөөд бид одоогоор компанийн тус салбаруудыг бэхжүүлэх, энэхүү бүрдүүлсэн баг болон нөөцийнхөө үр ашгийг амсаж эхэлж байна.

Петро Матад нь Газрын тосны хуулинд гарч болох өөрчлөлтийн талаар Засгийн газар болон газрын тосны салбарын бусад чухал төлөөлөгч нартай зөвлөлдөж байна. Энэхүү үйл явц үргэлжилсээр байгаа бөгөөд одоогоор нэмэлт өөрчлөлтийн талаар аливаа шийдвэр гарах хугацаа тодорхойгүй байна.

Манай компанийн бэлэн мөнгөний баланс 9-р сарын эхээр ойролцоогоор 25 сая ам доллар байв. Компани нь хайгуулын хөтөлбөрүүдээ дахин шинжлэн дүгнэж, шинэчлэх үе шатанд явж байгаа бөгөөд мөн үүнтэй холбоотойгоор төсвүүдээ ч шинэчлэх шатанд явж байгаа нь тус тайлангаас харагдаж байгаа болов уу.

Петро Матадын төрөл бүрийн төслүүдийг боловсруулах нь тун амаргүй даалгавар байсан боловч бид хайгуулын хөтөлбөрүүдийнхээ бүхий л хэсэгт ихээхэн хэмжээний илэрц ялангуяа судалгааны үе шатанд олдож байгааг тэмдэглэхэд таатай байна.

Манай захирлууд, удирдах ажилтнууд болон ажиллагсад маань хамгийн туршлагатай, мэргэжлийн хүмүүсээс бүрдэх удирдлагатай байсан ч гэсэн тун ярвигтай даалгаврын өмнө зогсож байгаагаа ойлгож, хайгуулын ажлын хувиралттай чанарыг ч ухаарч байна. Петро Матад нь тун бага судлагдсан салбарт хөл тавьж байгаа ба энэ нь сэтгэл хөдлөм “аян” боловч бид өөрсдийн оршин байгаа орчныг бүрэн ойлгож, бүрэн потенциалгаа илрүүлэхэд цаг хугацаа хэрэгтэй.

Саяхан Давсан толгойд хийгдсэн хайгуул нь тус анхдагч хайгуулын томоохон эрсдлүүдийг батлан харууллаа. Тус ажиллагаа нь урьдныхаас ч илүү нарийн төвөгтэй болохыг бид ойлгож байгаа ч Давсан толгойн ирээдүйд бид итгэлтэй хэвээр байгаа бөгөөд энэ газар хийгдэх хайгуул ба үүнийг дагалдах олборлолтын төлөө бид ихээхэн нөөц, эх сурвалжийг зарцуулах болно. Компанийн хайгуулын бусад хэсгүүдэд илэрсэн “ирээдүйтэй” нээлтүүд нь зорилготой бөгөөд эмх цэгцтэй хайгуулын ажлын үр дүнг зүй ёсоор харуулж байна. Мэдээж компани нь эдгээр хайгуулын төслүүдийг ахиулахын тулд ихээхэн нөөцийг зарцуулах болно. Давсан толгойн хөгжил ба манай хайгуулын бусад хөтөлбөрүүдийг гүйцэтгэхэд бид зохих чадвар, мэдлэг ба нөөцтэй гэдэгтээ бүрэн итгэлтэй байна.

Ирэх сарууд нь энэхүү тайланд дурьдсан ололт амжилт дээрээ үндэслэн цаашид урагшлан ахих, мөн тус тайланд дурьдсан олон хөтөлбөрүүдээс тогтмол ирэх мэдээлэл ба үр дүнгээр дүүрэн байх төлөвтэй байна.

Дуглас Жэй Макгей

Ерөнхий гүйцэтгэх захирал

2011 оны 9-р сарын 30

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 30 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог. IV Талбай нь ойролцоогоор 29,000 км², V Талбай нь ойролцоогоор 21,150 км² талбайг тус тус эзлэн оршдог.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний аралд (Isle of Man) үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспект Хилл, Даглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

**STATEMENT OF COMPREHENSIVE INCOME
FOR THE HALF-YEAR ENDED 30 JUNE 2011**

	Consolidated	
	30 Jun 2011 \$'000	30 Jun 2010 \$'000
Continuing Operations		
Revenue		
Interest Income	844	21
Other Income	-	5
	844	26
Expenditure		
Consultancy fees	56	59
Depreciation and amortisation	60	21
Employee benefits expenses	5,332	916
Exploration expenditure	9,614	1,309
Other expenses	967	569
	(16,029)	(2,874)
Loss from continuing operations before income tax		
Income tax expense	-	-
	(15,185)	(2,848)
Loss from continuing operations after income tax		
Net Loss	(15,185)	(2,848)
Other comprehensive loss		
Exchange rate differences on translating foreign operations	(34)	46
	(34)	46
Other comprehensive income, net of income tax		
Total comprehensive loss	(15,219)	(2,802)
Loss attributable to owners of the parent	(15,219)	(2,848)
Total comprehensive loss attributable to owners of the parent	(15,219)	(2,802)
Loss per share (cents per share)		
- Basic and diluted loss per share	8.27	2.08

**STATEMENT OF FINANCIAL POSITION
AS AT 30 JUNE 2011**

	Consolidated		
	30 Jun 2011 \$'000	31 Dec 2010 \$'000	30 Jun 2010 \$'000
ASSETS			
Current Assets			
Cash and cash equivalents	41,340	51,690	8,608
Trade and other receivables	335	88	63
Prepayments and other assets	631	354	82
	42,306	52,132	8,753
Total Current Assets			
Non-Current Assets			
Exploration and evaluation	15,275	15,275	15,275
Property, plant and equipment	912	450	249
	16,187	15,725	15,524
Total Non-Current assets			
TOTAL ASSETS	58,493	67,857	24,277

LIABILITIES**Current liabilities**

Trade and other payables	4,165	1,404	1,033
Provision for annual leave	14	17	7
Total Current Liabilities	4,179	1,421	1,040
TOTAL LIABILITIES	4,179	1,421	1,040
NET ASSETS	54,314	66,436	23,237

EQUITY

Issued capital	95,627	95,466	40,892
Reserves	6,802	3,900	2,044
Accumulated losses	(48,115)	(32,930)	(19,699)
TOTAL EQUITY	54,314	66,436	23,237

**CONDENSED CASH FLOW STATEMENT
FOR THE HALF YEAR ENDED 30 JUNE 2011**

	Consolidated	
	30 Jun 2011	30 Jun 2010
	\$'000	\$'000
Cash flows from operating activities		
Payments to suppliers and employees	(10,874)	(2,385)
Interest received	844	2
Net cash flows from/(used in) operating activities	(10,030)	(2,383)
Cash flows from operating activities		
Purchase of property, plant and equipment	(522)	(70)
Proceeds from the disposal of plant and equipment	-	-
Net cash flows from/(used in) investing activities	(522)	(70)
Cash flows from financing activities		
Proceeds from issue of shares	161	6,003
Capital raising costs	-	(157)
Net cash flows from/(used in) financing activities	161	5,846
Net increase/(decrease) in cash and cash equivalents	(10,391)	3,393
Net foreign exchange differences	41	-
Cash and cash equivalents at beginning of period	51,690	5,215
Cash and cash equivalents at end of period	41,340	8,608

**STATEMENT OF CHANGES IN EQUITY
FOR THE HALF YEAR ENDED 30 JUNE 2011**

Consolidated			
<i>Attributable to equity holders of the parent</i>			
Issued Capital \$'000	Accumulated Losses \$'000	Other Reserves \$'000	Total \$'000
		0	

As at 1 January 2010	35,115	(16,851)	1,766	20,030
Loss for the period	-	(2,848)	-	(2,848)
Other comprehensive income	-	-	46	46
Total comprehensive income for the period	-	(2,848)	46	(2,802)
<i>Transactions with owners in their capacity as owners</i>				
Issue of share capital	6,003	-	-	6,003
Cost of capital raising	(226)	-	-	(226)
Share based payments	-	-	232	232
As at 30 June 2010	40,892	(19,699)	2,044	23,237
As at 1 January 2011	95,466	(32,930)	3,900	66,436
Loss for the period	-	(15,185)	-	(15,185)
Other comprehensive income	-	-	(34)	(34)
Total comprehensive income for the period	95,466	(48,115)	3,866	51,217
<i>Transactions with owners in their capacity as owners</i>				
Issue of share capital	161	-	-	161
Cost of capital raising	-	-	-	-
Share based payments	-	-	2,936	2,936
As at 30 June 2011	95,627	(48,115)	6,802	54,314

1. CORPORATE INFORMATION

The financial report covers the consolidated entity of Petro Matad Limited and its controlled entities.

Petro Matad Limited is a company incorporated in the Isle of Man on 30 August 2007, which has five wholly owned subsidiaries, Capcorp Mongolia LLC and Petro Matad LLC (both incorporated in Mongolia), Central Asian Petroleum Corporation Limited and Petromatad Invest Limited (both incorporated in the Cayman Islands), and Petro Matad Services Limited (incorporated in the Isle of Man). Together collectively referred to as the "Group".

2. SUMMARY OF SIGNIFICANT ACCOUNTING POLICIES

The half-year financial report does not include all of the notes of the type normally included within the annual financial report and therefore cannot be expected to provide as full an understanding of the financial performance, financial position and financing and investing activities of the consolidated entity as the full financial report.

The half-year financial report should be read in conjunction with the annual Financial Report of Petro Matad Limited as at 31 December 2010. The half-year consolidated financial statements have been prepared using the same accounting policies as used in the annual financial statements for the year ended 31 December 2010.

It is also recommended that the half-year financial report be considered together with any public announcements made by Petro Matad Limited and its controlled entities during the half-year ended 30 June 2011.

(a) Basis of Preparation

The half-year consolidated financial report is a general purpose financial report, which has been prepared in accordance with the requirements of Australian equivalents to International Financial Reporting Standards ("IFRS") and AASB 134. The half-year financial report has been prepared on a historical cost basis, except where stated.

The financial report is presented in US dollars and all values are rounded to the nearest thousand dollars (\$'000).

For the purpose of preparing the half-year financial report, the half-year has been treated as a discrete reporting period.

(b) Basis of consolidation

The half-year consolidated financial statements comprise the financial statements of Petro Matad Limited and its controlled subsidiaries ('the Group').

Subsidiaries are entities controlled by the Group. Control exists when the Group has the power to govern the financial and operating policies of an entity so as to obtain benefits from its activities. In assessing control, potential voting rights that presently are exercisable or convertible are taken into account. The financial statements of the subsidiaries are included in the consolidated financial statements from the date that control commences until the date that control ceases.

The financial statements of subsidiaries are prepared for the same reporting period as the parent company, using consistent accounting policies. Adjustments are made to bring into line any dissimilar accounting policies that may exist.

All intercompany balances and transactions, including unrealised profits arising from intra-group transactions, have been eliminated in full. Unrealised losses are eliminated unless costs cannot be recovered.

3. CONTRIBUTED EQUITY

	CONSOLIDATED	
	30 Jun 2011	31 Dec 2010
	\$'000	\$'000
Ordinary shares (i)		
184,190,287 shares paid up (31 Dec 2010: 183,061,577)	95,627	95,466
	95,627	95,466

(i) Ordinary shares

Full paid ordinary shares carry one vote per share and carry the right to dividends.

<i>Movement in ordinary shares on issue</i>	Number of Shares	Issue Price\$	\$'000
At 1 January 2011	183,061,577		95,466
Vesting of service and bonus share awardson 25 March 2011	191,479	\$0.010	2
Issue of shares to directors and employees on 12 April 2011 on exercise of options	628,750	\$0.180	113
Issue of shares to director on 12 April 2011on exercise of options	50,000	\$0.750	38
Vesting of service share awardson 21 April 2011	142,447	\$0.010	1
Issue of shares to employees on 21April 2011on exercise of options	25,000	\$0.180	5
Vesting of service and bonus share awardson 10 June 2011	83,534	\$0.010	1
Issue of shares to employees on 10 June 2011on exercise of options	7,500	\$0.180	1
Capital raising costs			-
At 30 June 2011	184,190,287		95,627

4. RESERVES

A detailed breakdown of the reserves of the Group is as follows:

Consolidated	Merger reserve \$'000	Equity benefits reserve \$'000	Foreign currency translation \$'000	Total \$'000
As at 1 June 2010	831	1,243	(30)	2,044
Currency translation differences	-	-	(114)	(114)
Share based payments	-	1,970	-	1,970
As at 31 December 2010	831	3,213	(144)	3,900
Currency translation differences	-	-	(34)	(34)
Share based payments	-	2,936	-	2,936
As at 30 June 2011	831	6,149	(178)	6,802

5. LOSS PER SHARE

Basic loss per share amounts are calculated by dividing net loss for the period attributable to ordinary equity holders of the parent by the weighted average number of ordinary shares outstanding during the period.

Diluted loss per share amounts are calculated by dividing the net loss attributable to ordinary shareholders (after deducting interest on the convertible redeemable preference shares) by the weighted average number of ordinary shares outstanding during the period (adjusted for the effects of dilutive options and dilutive convertible redeemable preference shares).

	CONSOLIDATED	
	30 Jun 2011	30 Jun 2010
Basic loss per share		
Total basic loss per share (US\$ cents per share)(note a)	<u>(8.27)</u>	<u>(2.08)</u>
Diluted loss per share		
Total diluted loss per share (US\$ cents per share) (note b)	<u>(8.27)</u>	<u>(2.08)</u>
(a) Basic loss per share		
The loss and weighted average number of ordinary shares used in the calculation of basic loss per share are as follows:		
Net loss attributable to ordinary shareholders (US\$'000)	<u>15,185</u>	<u>2,848</u>
Weighted average number of ordinary shares for the purposes of basic earnings per share ('000)	<u>183,541</u>	<u>136,975</u>
(b) Diluted loss per share		
The loss and weighted average number of ordinary shares used in the calculation of diluted earnings per share are as follows:		
Net loss attributable to ordinary shareholders(US\$'000)	<u>15,185</u>	<u>2,848</u>
Weighted average number of ordinary shares for the purposes of basic earnings per share('000)	<u>183,541</u>	<u>136,975</u>

Share options and Performance Share Awards could potentially dilute basic loss per share in the future, however they have been excluded from the calculation of diluted loss per share because they are anti-dilutive for both years presented.

6. EVENTS AFTER THE REPORTING DATE

On 5 July 2011, pursuant to the Group's Long Term Equity Incentive Plan ("Plan"), 150,000 Options on ordinary shares, with an exercise price of GBP£1.17 per share, and 150,000 Performance Share Awards on ordinary shares, with an exercise price of \$0.01 per share were issued to newly appointed Director, Ms Davaanyam Enkhmaa. The vesting terms of the Options provide that 33% shall vest on the first anniversary of the date of grant, 33% on the second anniversary & 34% on the third anniversary, while the vesting terms of the Awards provide that 25% shall vest on the first discovery of oil on a commercial basis, 25% on the first production of oil on a commercial scale and 50% on the Group achieving the sale of 1 million barrels of oil.

On 5 July 2011, pursuant to the Group's Plan, 473,000 Options on ordinary shares, with an exercise price of GBP£1.17 per share were issued to employees. The vesting terms relating to 413,000 of the Options, provide that 33% shall vest on the first anniversary of the date of grant, 33% on the second anniversary and 34% on the third anniversary, while the vesting terms relating to 60,000 of the Options provide that 33% shall vest on the first anniversary of the date of employment commencement, 33% on the second anniversary and 34% on the third anniversary.

On 5 July 2011, pursuant to the Group's Plan, 581,268 Performance Share Awards on ordinary shares, with an exercise price of \$0.01 per share were issued to employees. The vesting terms relating to 433,000 of the Awards provide that 25% shall vest on the first discovery of oil on a commercial basis, 25% on the first production of oil on a commercial scale and 50% on the Group achieving the sale of 1 million barrels of oil; a further 47,181 vested on the issuing date and 25,000 on 24 July 2011, 6,964 will vest on various dates from 2 September 2011 to 4 October 2011, and 31,623 and 37,500 will vest in three equal annual instalments of 10,541 and 12,500 respectively from 2 May 2012 and 4 July 2012 respectively.

On 5 August 2011, pursuant to the Group's Plan, employees and a retiring director were issued with a total of 97,497 shares on exercise of Performance Share Awards at an exercise price of \$0.01 per share, and 189,090 shares were also issued to employees on exercise of Options, with 5,000 issued at an exercise price of GBP£0.11 per share and 184,090 issued at an exercise price of GBP£0.4616 per share.

No other matters or circumstances have arisen after the balance sheet date that have significantly affected, or may significantly affect, the operations of the consolidated entity, the results of those operations, or the state of affairs of the consolidated entity in future periods.